МЭДЭЭ · 2021 оны 3-р сарын 10

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭЖ АЖИЛЛАЖ БАЙНА



Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын прокурорын газар нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллахаар болсон байна. Энэ ажлын хүрээнд иргэд олон нийтэд сум, орон нутгийн хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчил, түүний шалтгаан нөхцөл болон урьдчилан сэргийлэх асуудлаар мэдээ, мэдээллийг тогтмол хүргэж байхаар болжээ.

Улмаар дээрх хамтын ажиллагааг эхлүүлж, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор Ш.Дамдинбазар, хяналтын прокурор Н.Амаржаргал, М.Мэндбаяр нар сум дундын прокурорын газрын үйл ажиллагаа, харьяа сумдад 2020 онд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар тус аймгийн “Өндөрхаан” телевизэд ярилцлага өгсөн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2805